



**МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН ХООРОНД
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА
ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ**

ГЭРЭЭ

Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэнэ/ нь:

Талууд эрүүгийн хэргийн талаар хамтран ажиллах болон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх замаар гэмт хэрэг (алан хядах ажиллагааг оролцуулан)-ийг мөрдөн байцаах, яллах, таслан зогсоох ажиллагааны үр дүнтэй байдлыг дээшлүүлэхийг эрмэлзэн;

дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

I БҮЛЭГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх үүрэг

1. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү Гэрээний дагуу өргөн хүрээнд эрүүгийн хэргийн талаар туслалцаа харилцан үзүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан зорилгод нийцүүлэн харилцан туслалцаа үзүүлэх гэдэгт шүүх болон бусад эрх бүхий байгууллагаас туслалцаа үзүүлэх тухай хүсэлт гаргасан, биелүүлсэн эсэхийг үл харгалзан Хүсэлт гаргасан Талын хэргийн харъяалалд мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаатай холбогдуулан Хүсэлт хүлээн авсан Талаас эрүүгийн хэргийн талаар үзүүлэх бүх туслалцааг ойлгоно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорилгод нийцүүлэн эрүүгийн хэрэг гэдэгт Монгол Улсын хувьд тус улсын эрүүгийн хууль тогтоомжид заасан гэмт хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хувьд тус улсын Парламент болон муж улсын хууль тогтоох байгууллагаас гаргасан хуулинд заасан гэмт хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааг ойлгоно.

4. Эрүүгийн хэрэг гэдэгт алан хядах ажиллагааг дэмжсэн гэмт хэрэг болон татвар, хураамж, гааль, эд хөрөнгө, төлбөр тооцооны олон улсын шилжүүлэгтэй холбогдсон эрүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааг багтаана.



5. Дээрхээс гадна эрүүгийн хэрэг гэдэгт алан хядах ажиллагаа бүхий гэмт хэрэг тухайлбал олон нийтийг айлган цочирдуулах, улс төрийн зорилгоор хүч хэрэглэх зэрэг эрүүгийн хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааг мөн багтаана.

6. Дараахь туслалцааг үзүүлнэ:

- 6.1.Холбогдох этгээд, объектийг илрүүлэх, тогтоох;
- 6.2.Холбогдогч этгээдийг зарлан дуудах баримт бичгийг гардуулах;
- 6.3.Эрүүгийн хавтаст хэрэг, шүүх, Засгийн газрын тэмдэглэл зэрэг мэдээлэл, баримт бичиг болон бусад тэмдэглэлээр хангах;
- 6.4.Эд хөрөнгө шилжүүлэх;
- 6.5.Эд мөрийн нотлох баримтыг түр шилжүүлэх;
- 6.6.Гэрчийн болон бусад этгээдийн мэдүүлэг болон нотлох баримт авах;
- 6.7.Эрэн сурвалжлах болон баривчлах хүсэлтийг биелүүлэх;
- 6.8.Нотлох баримт өгөх, мөрдөн байцаалтад туслалцаа үзүүлэх шинжээч, цагдан хоригдож буй этгээд болон бусад этгээдүүд;
- 6.9. Гэмт хэргийн эд материал, хөрөнгийг илрүүлэх, тусгаарлах, битүүмжлэх, хураах арга хэмжээ авах;
- 6.10.Алан хядах ажиллагаанд зориулагдсан аливаа хөрөнгийг илрүүлэх, тогтоох, тусгаарлах, битүүмжлэх, хураан авах зэрэг арга хэмжээг авах;
- 6.11.Энэхүү Гэрээний зорилгод нийцсэн бусад туслалцаа.

2 дугаар зүйл

Хүсэлтийг биелүүлэх

1.Туслалцаа авах тухай хүсэлтийг Хүсэлт хүлээн авсан Талын хууль тогтоомжийн дагуу биелүүлэх ба хэрэв тухайн улсын хуулиар хориглоогүй бол Хүсэлт гаргасан Талын тодорхойлсон саналын дагуу даруй биелүүлнэ.

2.Хүсэлт гаргасан Тал тусгайлан хүссэн үед Хүсэлт хүлээн авсан Тал тухайн хүсэлтийг биелүүлэх хугацаа болон газрыг Хүсэлт гаргасан Талд мэдэгдэнэ.

3.Хүсэлт хүлээн авсан Тал банкны нууцын үндэслэлээр хүсэлтийг биелүүлэхээс татгалзах эрхгүй.

3 дугаар зүйл

**Туслалцаа үзүүлэхээс татгалзах
буюу хойшлуулах**

1.Хүсэлт хүлээн авсан Тал тухайн хүсэлтийг биелүүлэх нь тус улсын бүрэн эрх, аюулгүй байдал, нийгмийн дэг журам болон нийгмийн бусад нэн чухал ашиг сонирхлыг хөндөнө гэж үзвэл уг хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж болно.

2.Хүсэлтийг биелүүлэх нь Хүсэлт хүлээн авсан Талын харъяалах хэрэгт явуулж байгаа мөрдөн байцаалт буюу яллах ажиллагаанд саад учруулахаар бол Хүсэлт хүлээн авсан Тал хүсэлтийг биелүүлэхийг хойшлуулж болно.



3.Хүсэлт хүлээн авсан Тал тухайн хүсэлтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлэх, эсхүл хүсэлтийг биелүүлэхийг хойшлуулах тухай шийдвэрийг Хүсэлт гаргасан Талд нэн даруй мэдэгдэж ийнхүү шийдвэр гаргах болсон үндэслэлийг тайлбарлана.

4.Туслалцаа үзүүлэх хүсэлтийг биелүүлэхээс татгалзах буюу хойшлуулах шийдвэр гаргахаасаа өмнө Хүсэлт хүлээн авсан Тал тухайн хүсэлтийг боломжтой гэж үзсэн нөхцлөөр биелүүлж болох эсэхийг авч үзнэ. Хэрэв Хүсэлт хүлээн авсан Талын тавьсан нөхцөл, болзлыг Хүсэлт гаргасан Тал зөвшөөрөөл түүнийг биелүүлнэ.

II БҮЛЭГ

Тусгай заалт

4 дүгээр зүйл

Хувь хүнийг танин тогтоох буюу
объектыг илрүүлэх, тогтоох

Хүсэлт хүлээн авсан Талын эрх бүхий байгууллагууд хүсэлтэд заасан хувь хүнийг таньж тогтоох болон объектийг илрүүлэн, тогтоох талаар бүхий л хүн чармайлтаа гарган ажиллана.

5 дугаар зүйл

Баримт бичгийг гардуулах

1.Хүсэлт хүлээн авсан Тал түүнд хүргүүлсэн аливаа баримт бичгийг гардуулах ажиллагааг гүйцэтгэнэ.

2.Хүсэлт гаргасан Тал нь өөрийн харъяалах хэрэгтэй холбогдуулан ирэх буюу хариу өгөх талаархи аливаа баримт бичгийг гардуулах тухай хүсэлтээ тухайн газарт очих, хариу өгөх ёстой хугацаанаас хангалттай хугацааны өмнө гаргана. "Хангалттай хугацаа" гэдгийг тогтоохдоо Хүсэлт хүлээн авсан Талын нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

3.Хүсэлт хүлээн авсан Тал нь баримт бичгийг гардуулсан баталгаа Хүсэлт гаргасан Талын шаардсан хэлбэрээр гаргана. Гардуулахаас хоцроосон буюу гардуулах боломжгүй бол Хүсэлт гаргасан Талд шалтгааныг мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

Баримт бичиг болон эд зүйл шилжүүлэх

1.Хэрэв хүсэлтийн дагуу протокол болон баримт бичиг шилжүүлэхээр бол Хүсэлт хүлээн авсан Тал уг баримт бичгийн баталгаажуулсан хувийг шилжүүлж болно. Гэхдээ Хүсэлт гаргасан Талын баримт бичгийн эх хувийг нь тусгайлан хүссэн бол Хүсэлт хүлээн авсан Тал уг хүсэлтийг биелүүлэх талаар боломжтой бүхнийг хийнэ.

2.Хүсэлт гаргасан Талд шилжүүлсэн протоколын эх хувь, баримт бичиг болон эд зүйлийг Хүсэлт хүлээн авсан Талаас хүссэн тохиолдолд богино хугацаанд эргүүлэн өгнө.



3.Хүсэлт хүлээн авсан Талын хууль тогтоомжоор хориглоогүй бол Хүсэлт гаргасан Талд хүсэлтийн дагуу шилжүүлэх протокол, баримт бичиг буюу эд зүйлийг Хүсэлт гаргасан Талын хуульд нийцүүлэх зорилгоор нөгөө Талын хүссэн хэлбэрээр эсхүл тэдгээрийг гэрчлэх батламж бичгийг хавсарган шилжүүлнэ.

7 дугаар зүйл

Хүсэлт хүлээн авсан Талын шүүн таслах
ажиллагаанд оролцох этгээдийг байлцуулах

1.Хүсэлт хүлээн авсан Талын гаргах баримт бичиг, протокол буюу эд зүйл мөн мэдүүлэг өгөх этгээдийг, шаардлагатай бол тэдгээр баримт бичиг, протокол буюу эд зүйлийг гаргуулах, байцаалт, мэдүүлэг өгөх шүүхийн зарлан дуудах хуудас буюу захирамжийг Хүсэлт хүлээн авсан Талын хуулийн дагуу гаргаж албадан ирүүлж болно.

2.Хүсэлт хүлээн авсан Тал өөрийн хуулийн дагуу хүсэлтийг биелүүлэхэд уг хүсэлтэд заасны дагуу дээрх этгээдийг байлгахыг зөвшөөрч байцаагдаж буй этгээдэд асуулт тавихыг зөвшөөрч болно.

3.Хүсэлтийг биелүүлэхэд байлцаж буй этгээд тухайн байцаан шийтгэх ажиллагсааны ярианы тэмдэглэл хийхийг зөвшөөрнө. Хүсэлт хүлээн авсан Талын хуулиар хориглоогүй бол тухайн тэмдэглэлийг техник, төхөөрөмж ашиглан хийхийг зөвшөөрнө.

8 дугаар зүйл

Хүсэлт гаргасан Талын харъяалах хэрэгт
нотлох баримт өгөх буюу мөрдөн байцаалтад
туслалцаа үзүүлэх этгээд бэлэн байлгах

1.Хүсэлт гаргасан Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талд мэдүүлэг өгөх буюу мөрдөн байцаалтад туслалцаа үзүүлж чадах этгээдийг гаргаж өгөхийг хүсч болно.

2.Хүсэлт хүлээн авсан Тал тухайн этгээдийг мөрдөн байцаалтад туслалцаа үзүүлэх болон шүүн таслах ажиллагаанд гэрчээр урьж оролцуулах бөгөөд тухайн хүнийг аль болох сайн дураар оролцуулахыг хичээнэ. Олгох төлбөрийн талаар тухайн этгээдэд мэдэгдсэн байна. Хүсэлт хүлээн авсан Тал тухайн этгээдийн хариут Хүсэлт гаргасан Талд даруй мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл

Үзлэг хийх ба хураах

1.Үзлэг хийх, хураах тухай хүсэлтийг биелүүлсэн эрх бүхий байгууллага хураагдсан баримт бичиг, протокол, эд зүйлийн тодорхойлолт, нөхцөл байдал, үргэлжлэх хугацаа болон хураах нөхцөл зэргээр хязгаарлахгүйгээр Хүсэлт гаргасан Талын хүсэлтийн дагуу бусад мэдээллээр хангана.



2. Хүсэлт гаргасан Талд шилжүүлж болох хурааж авсан баримт бичиг, протокол болон эд зүйлийн талаар Хүсэлт хүлээн авсан Талын тавьсан шаардлага, нөхцлийг Хүсэлт гаргасан Тал биелүүлнэ.

10 дугаар зүйл

Нотлох баримт гаргах буюу мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлж болох этгээдийг цагдан хорих

1.Хүсэлт хүлээн авсан Талын хуулийн дагуу цагдан хоригдож буй этгээдийг Хүсэлт гаргасан Талын хүсэлтээр мөрдөн байцаалтад туслалцаа үзүүлэх буюу шүүх таслах ажиллагаанд мэдүүлэг өгүүлэхээр түр хугацаагаар шилжүүлнэ. Гэхдээ уг этгээд шилжүүлэхийг зөвшөөрсөн байх ёстой бөгөөд түүнийг шилжүүлэхэд саад болохооргүй байна. Хүсэлт гаргасан Тал уг этгээдийг цагдан хорих бөгөөд хүсэлтийг биелүүлсний дараа Хүсэлт хүлээн авсан Талд буцаана.

2. Оногдуулсан ялын хугацаа дууссан буюу Хүсэлт хүлээн авсан Тал Хүсэлт гаргасан Талд тухайн этгээдийг цаашид цагдан хорих шаардлагагүй болохыг мэдэгдвэл түүнийг чөлөөлж энэхүү гэрээний 8 дугаар зүйлд заасан этгээдтэй адил үзнэ.

11 дүгээр зүйл

Аюулгүй үйл ажиллагаа

1.Хүсэлт гаргасан Талын хүсэлтийн дагуу байцаан шийтгэх ажиллагаанд биеэр оролцохоор хүрэлцэн ирсэн этгээдийг энэхүү гэрээний 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд албадан саатуулах, хувийн эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарлах түүнчлэн түүнийг Хүсэлт хүлээн авсан Талын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө хийсэн аливаа үйлдэл болон эс үйлдэлд нь ял тулгаж болохгүй бөгөөд тэрээр уг хүсэлтэд дурдснаас өөр шүүн таслах ажиллагаанд мэдүүлэг өгөх үүрэг хүлээхгүй.

2 Аливаа этгээдийг биечлэн байлгах шаардлагагүй хэмээн албан ёсоор мэдэгдсэнээс хойш тухайн этгээд нь 30 хоногийн хугацаанд Хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрээс ийнхүү гарч явах нь чөлөөтэй байсан боловч гарч яваагүй, эсхүл гарч явсан боловч сайн дураар буцан ирсэн тохиолдолд энэхүү зүйлийн 1 дэх хэсэг үйлчлэхгүй.

3.Хүсэлт гаргасан Талын шүүн таслах ажиллагаанд биеэр хүрэлцэн ирээгүй этгээдэд Хүсэлт хүлээн авсан Талаас аливаа ял шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авахгүй байж болно.



12 дугаар зүйл

Гэмт хэргийн улмаас
олсон эд хөрөнгө, ашиг

1.Хүсэлт хүлээн авсан Тал хүсэлтийн дагуу өөрийн хэргийн харъяалалд алан хядах ажиллагаанд зориулах хөрөнгө, мөнгө зэрэг гэмт хэргийн улмаас олсон эд хөрөнгө, ашиг байгаа эсэхийг нягтлан тодруулж, ийнхүү шалган үзсэн үр дүнгийн талаар Хүсэлт гаргасан Талд мэдэгдэнэ.

2.Алан хядах ажиллагаанд зориулах хөрөнгө, мөнгө зэрэг гэмт хэргийн улмаас олсон эд хөрөнгө, ашгийг хураан авах, эсхүл хохиролыг баталгаажуулахад туслалцаа авахаар хүсэлт тавьж болно. Ийм туслалцааг Хүсэлт хүлээн авсан Талын хуулийн дагуу зохих хэлбэрээр үзүүлнэ. Энэ нь Хүсэлт гаргасан Талын шүүхийн болон холбогдох бусад эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх, Хүсэлт хүлээн авсан Талын зохих эрх бүхий байгууллагад Хүсэлт хүлээн авсан Тал нөхөн төлбөртэй хураан авах тухай шийдвэрийг уламжлах зэрэг туслалцаа байж болно.

3.Олсон эд хөрөнгө, ашгийг нөхөн олгох тухай шийдвэрийн биелэлтийг хангахын тулд тухайн эд хөрөнгийн зарцуулалтад хязгаарлалт тавих хүсэлт гаргаж болно.

4.Энэхүү гэрээний дагуу нөхөн төлбөртэй хураагдсан эд хөрөнгө, ашгийг өөрөөр тохиролцоогүй бол Хүсэлт хүлээн авсан Талын орлогод үлдэнэ.

5.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлтийг биелүүлэхээр арга хэмжээ авсан болон түүнд холбогдох этгээдийн төлөөлөгч Монгол Улс эсхүл Бүгд Найрамдах Энэтхэг Улсад байгаа бол энэ тухай Хэлэлцэн тохирогч Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талд аль болох богино хугацаанд мэдэгдэж уг төлөөлөгчийн талаар даруй мэдээлнэ.

III БҮЛЭГ

БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА

13 дугаар зүйл

Хүсэлтийн агуулга

1. Аль ч тохиолдолд туслалцаа хүссэн хүсэлтэд дараах зүйлийг тусгана.

1.1.Хүсэлттэй холбогдсон хэрэгт мөрдөн байцаах, яллах болон шүүн таслах ажиллагааг гүйцэтгэх эрх бүхий байгууллага;

1.2.Холбогдох хууль, баримтын хураангуй болон хуулбар зэрэг мөрдөн байцаах, яллах болон шүүн таслах ажиллагааны мөн чанарын тодорхойлолт;

1.3. Гаргаж байгаа хүсэлтийн зорилго, чухам ямар туслалцаа хүсч буй тухай;

1.4.Хүсэлтийн хариу авах хугацаа.

2.Туслалцаа хүссэн хүсэлт нь дараах мэдээллийг мөн тусгасан байна.

2.1.Боломжтой тохиолдолд мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны оролцох хувь хүн болон бусад этгээдүүдийн таних тэмдэг, иргэний харъяалал болон байршил;



2.2. Шаардлагатай тохиолдолд Хүсэлт гаргасан Талаас дагаж мөрдөхийг хүссэн тусгай журам, шаардлага;

2.3. Мэдүүлэг авах, үзлэг хийх, хураан авах тухай хүсэлт тавихад Хүсэлт хүлээн авсан Талын харъяалалд нотлох баримт болзошгүй тухай үндэслэлийн тайлбар;

2.4. Аливаа этгээдээс мэдүүлэг авах тохиолдолд уг мэдүүлгийг өгөхдөө үнэн зөв болохыг тангарагласан, баталсан эсхүл Хүсэлт хүлээн авсан Талын хуульд нийцүүлэн өөр аргаар өгсөн тухай мэдээлэл болон мэдүүлгийн талаарх тайлбар;

2.5. Эд мөрийн нотлох баримтыг түр авч ашиглах тохиолдолд тухайн нотлох баримтыг хадгалах этгээд буюу бүлэг этгээд, нотлох баримтыг шилжүүлэх газар, хийх шинжилгээ, нотлох баримтыг буцааж өгөх он, сар, өдөр;

2.6. Цагдан хоригдож буй этгээдийг шилжүүлэх тохиолдолд шилжүүлэх үед хяналт тавих этгээд, бүлэг этгээд, цагдан хоригдож буй этгээдийг шилжүүлэх газар, түүнийг буцааж өгөх он, сар, өдөр;

2.7. Хэрэв нууцлах шаардлагатай бол нууцлах шалтгаан;

2.8. Хүсэлтийг биелүүлэхэд шаардлагатай байж болох бусад мэдээлэл.

3. Хүсэлт хүлээн авсан Тал хүсэлтэд заасан мэдээлэл нь уг хүсэлтийг биелүүлэхэд хангалтгүй гэж үзвэл нэмэлт тодорхой мэдээлэл хүсч болно.

4. Хүсэлтийг бичгээр үйлдэнэ. Яаралтай буюу Хүсэлт хүлээн авсан Тал өөр хэлбэрээр тавихыг зөвшөөрсөн бол хүсэлтийг факс, эсхүл бусад тохиролцсон цахилгаан холбоогоор хүргүүлж болох боловч дараа нь эх хувийг даруй хүргүүлэн баталгаажуулна.

14 дүгээр зүйл

Эрх бүхий Төв байгуулага

Энэхүү Гэрээний дагуу хүсэлт тавих, хариу хүлээж авах, дамжуулах ажлыг эрх бүхий Төв байгууллагууд гүйцэтгэнэ. Монгол Улсын хувьд эрх бүхий Төв байгууллага нь "Монгол Улсын Ерөнхий прокурорын газар", Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хувьд "Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Дотоод явдлын яам" байх болно.

15 дугаар зүйл

Нууц хадгалах

1. Хүсэлт хүлээн авсан Тал зөвхөн тодорхой нөхцөл, болзолтойгоор нууцлан, ашиглахаар мэдээллийн эх сурвалж, нотлох баримтыг шаардаж болно. Хэрэв Хүсэлт гаргасан Тал нөхцөл болзолтойгоор аливаа мэдээлэл, нотлох баримтыг авч ашиглаж байгаа бол тэдгээр нөхцөл, болзлыг биелүүлнэ.

2. Хүсэлт хүлээн авсан Тал хүсэлт гаргасан даруйд шаардсан хэмжээнд тухайн хүсэлт, түүний агуулга, дагалдах баримт бичиг, хүсэлтийн дагуу авсан аливаа арга хэмжээг нууцлана. Хэрэв хүсэлтийг нууцыг задруулалгүйгээр гүйцэтгэх боломжгүй бол Хүсэлт хүлээн авсан Тал Хүсэлт гаргасан Талд энэ талаар мэдэгдэнэ. Хүсэлт гаргасан Тал хүсэлтийг тухайн нөхцөлд биелүүлэх эсэхээ шийдвэрлэнэ.



16 дугаар зүйл
Ашиглалтад тавих шаардлага

Хүсэлт гаргасан Тал хүсэлтэд зааснаас өөр бусад зорилгод мэдээлэл, нотлох баримтыг Хүсэлт хүлээн авсан Талын эрх бүхий Төв байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр ашиглаж болохгүй.

17 дугаар зүйл
Баталгаажуулалт

Энэхүү Гэрээний дагуу шилжүүлэх аливаа нотлох баримт болон баримт бичгийг уг Гэрээний 6 дугаар зүйлд заасан хэлбэрээр баталгаажуулсан байхыг шаардахгүй.

18 дугаар зүйл
Харилцах хэл

Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн хэлийг хэрэглэх бөгөөд ингэхдээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талын үндэсний хэл эсхүл англи хэл дээрх орчуулгыг нь хавсаргасан байна.

19 дүгээр зүйл
Консулын ажилтан

1.Консулын ажилтан тухайн Хүсэлт хүлээн авсан Талын нутаг дэвсгэр дээр албан ёсны хүсэлт тавихгүйгээр гэрчийн мэдүүлгийг сайн дурын үндсэн дээр авч болно. Ийнхүү мэдүүлэг авах ажиллагааны тухай Хүсэлт хүлээн авсан Талд урьдчилан мэдэгдсэн байна. Хүсэлт хүлээн авсан Тал энэхүү Гэрээний 3 дугаар зүйлд заасан үндэслэлээр зөвшөөрөл өгөхөөс татгалзаж болно.

2.Консулын ажилтан түүний байранд сайн дураараа хүрэлцэн ирсэн хувь хүнд баримт бичгийг гардуулан өгч болно.

20 дугаар зүйл
Зардал

1.Хүсэлт хүлээн авсан Тал нь Хүсэлт гаргасан Талын хариуцах дараах зардлаас бусад зардлыг хариуцна:

1.1.Энэхүү Гэрээний 7, 8 дугаар зүйлд заасан хүсэлтийн дагуу аливаа этгээдийг Хүсэлт гаргасан Талын хүсэлтээр Хүсэлт хүлээн авсан Талын харъяалалд шилжүүлж өгөх, авахтай холбогдсон зардал, түүнд Хүсэлт гаргасан Талын харъяалалд байх хугацаанд нь олгох аливаа төлбөр;

1.2.Хүсэлт гаргасан Тал буюу Хүсэлт хүлээн авсан Талын нутаг дэвсгэрт байх шинжээчийн зардал, хөлс.



2.Хэрэв хүсэлтийг биелүүлэхэд их хэмжээний хэвийн бус зардал гарах нь тодорхой байгаа бол, Хэлэлцэн тохирогч Талууд туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг биелүүлэх болзол, нөхцлийг тогтоохоор харилцан зөвлөлдөнө.

IV БҮЛЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

21 дүгээр зүйл

Хамтын ажиллагааны талаарх бусад үндэс

Энэхүү Гэрээ нь Хэлэлцэн тохирогч Талуудын байгуулсан бусад гэрээ, зохицуулалтаас үүдэн гарах үүргийг хөндөхгүй буюу бусад Гэрээний дагуу туслалцаа үзүүлэх явдлыг хориглохгүй.

22 дугаар зүйл

Хамрах хүрээ

Энэхүү Гэрээ нь хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө буюу хойш гарсан аливаа хүсэлтэд нэгэн адил үйлчилнэ.

23 дугаар зүйл

Зөвлөгөө

Хэлэлцэн тохирогч нэг Талын хүсэлтээр Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Гэрээг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг тайлбарлан хэрэглэх талаар нэн даруй зөвлөлдөж байна.

24 дүгээр зүйл

Гэрээг батлах, дуусгавар болгох

1.Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг солилцсон өдрөөс хойш 30 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2.Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Гэрээг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа бичгээр мэдэгдээгүй бол энэхүү Гэрээ хүчинтэй хэвээр тооцогдоно. Ийнхүү цуцлах тухай мэдэгдэл өгсөн өдрөөс хойш зургаан сарын дараа энэхүү Гэрээ нь хүчингүй болно.

Дээрхийг нотлон тус тусын Засгийн газраас албан ёсны дагуу эрх олгогдсон доорхи хүмүүс энэхүү Гэрээнд гарын үсэг зурав.



Энэхүү Гэрээг 2001 оны 1 сарын 3-ны өдөр монгол, хинди, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Энэхүү Гэрээг тайлбарлахад маргаан гарвал англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ